

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ ИРГЭД, ААНБ БОЛОН СӨХ-НООС
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2022 ОНЫ МЭДЭЭ

2022 оны 12 дугаар сарын 27 өдөр

Улаанбаатар хот

№	Төрөл	Хүлээн авсан он сар өдөр	Товч утга	Шийдвэрлэсэн байдал
1		Гомдол 2021-12-27	Х апартмент-2 хотхоны оршин суугч иргэн байна. Эко констракшны барьсан хотхон байгаа юм. Ахуй байдлаар эрүүдэн шүүлгээд байх боллоо. 16 давхар орон сууц мөртлөө нэгхэн хуучин лифттэй, тус барилгыг барьсан байгууллагад хандахаар улсын комисс хүлээж авсан одоо бид нарт хамаагүй гэх юм ийм байж болох уу?	2022-01-03 Ерөнхий инженер М.Энхбат: Улаанбаатар хот, БЗД 8-р хороо, Х апартмент 2 хотхоны 15-122 тоотод оршин суугч М.Одбаярын гаргасан М211227001 тоот гомдлын дагуу "Улаанаатар лифт" НӨҮГ-ын Ерөнхий инженер М.Энхбат, хяналтын инженер Б.Байгаль, механик инженер Я.Батбаатар нар очиж СӨХ-ны дарга Д.Хүрлээ, СӨХ-ны удирдах зөвлөлийн дарга Ц.Бямбасүрэн нарын хамт газар дээр нь лифтийг үзэж танилцлаа. Тус 16 давхар байр нь 2 зорчигчийн лифттэй ба 550 кг-ын даацтай Браун элеватор үйлдвэрийн лифт хэвийн ажиллаж байв. 2-дахь лифт 2016 онд үйлдвэрлэгдсэн 450 кг-ын даацтай 16 зогсоолтой Тиссенэлеватор үйлдвэрийн Х апартмент-1 дээр ашиглаж байсан лифтийг суурилуулсан тул СӨХ хүлээж аваагүйн улмаас маргаан үүсэн зогсоосон байв. Ашиглагч байгууллага лифтийг актаар хүлээж аваагүй, мэргэжлийн лифтчин байхгүй нь ЛТААД-н шаардлагад нийцэхгүй тул ажиллуулах боломжгүй. СӨХ 2 дахь лифтийг шинээр солиулах шаардлага тавьж байна. Гомдол гаргасан иргэнтэй биечлэн уулзаж нөхцөл байдлыг танилцууллаа.

6	Хүсэлт 2022-03-07	<p>Бид БЗД-ийн 25-р хорооны нутаг дэвсгэрт орших 36Б байрны оршин суугчид юм. Манай байр 1995 онд ашиглалтад орсон Орос ах нарын барьсан хамгийн сүүлийн байруудын нэг бөгөөд 27 жилийн насжилттай, 1 орцтой 9 давхар 72 айлтай 270 гаруй оршин суугчтай, өндөр настан болон тэтгэврийн насны олон оршин суугчтай. Манай байр "Говь" СӨХ харьяалагддаг боловч үйл ажиллагаа нь сүүлийн 5 жил муу тул бид тун хэцүү байдлаар аж төрж байна. Оршин суугч бидэнд маш олон тулгамдсан асуудал байдгийн нэг нь лифтний үйл ажиллагаа болно. 1. Лифт 27 жилийн насжилттай. 2. Лифт анх байр ашиглалтад орсноос хойш шинэчлэгдээгүй ашиглагдаж байна. 3. Лифт зогсолт ихтэй, өнгөрсөн он жилүүдэд үйлчилгээг гэрээг байгууллагаар хийлгэдэг боловч тэр нь тууштай хэвийн ажиллах боломжгүй байсаар өдийг хүрлээ. 4. Лифтийг нээх хавх үед дуу чимээ маш их арчилгаа тордлогоо хийгддэггүй зөвхөн лифтний шалыг арчих маягаар олон жил боллоо. 5. СӨХ-ны дарга Ц.Эрдэнэбаатар сүүлийн 2-3 жил лифтийг өөрөө ажиллуулдаг гэх боловч өглөөд явуулах, оройд зогсоох ажлыг байрны үйлчлэгч хийдэг. 6. Оршин суугчид лифтний талаар санал шүүмжлэл хэлэхэд СӨХ-ны дарга Ц.Эрдэнэбаатар шууд зогсоодог. 7. 2021 оны 12-р сард 10 хоног 2022 оны 1-р сард 5 хоног, цагаан сарын шинийн нэгний еглеееес буюу 2/2-с 2/5-ны хооронд 4 хоног, 2/22-с 2/24-ний хооронд таг зогссон. 8. Бид лифтээ солиулах талаар УБ хотын засаг дарга асан С.Амарсайхан, менежер асан Т.Гантөмөр, засаг дарга Д.Сумъяабазар нарт 2019, 2020, 2021 онуудад удаа дараа өргөдөл өгсөн боловч хариу авч үзээгүй. 9. Бид МУ-ын Засгийн газар Бүгд Найрамдах Беларусь Улсын Элчин сайдын яамны 2021.02 23 - ны гэрээ хэлэлцээрээр хийгдэх төслийн дагуу Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ. Элчин сайд В.С.Чепурной нарт захидал бичиж гэрээ хэлэлцээрээр хийлгэхийг хүссэн болно. Ерөнхий сайдын ажлын албан Элчин сайдын ажлын албанаас хариу өгөхдөө "Нийслэлдээ хандахыг илэрхийлсэн болно". 10. 2022 оны 1-р сард БЗД-ийн Тамгын газарт хандаж өргөдөл өгөхөд С.Ганхуяг гэдэг мэргэжилтэн хариу өгөхдөө "Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулах</p>	<p>2022-03-10</p> <p>Ерөнхий инженер М.Энхбат: Хүсэлтийг хүлээн авч танилцлаа. Хүсэлт гаргасан БЗД-ийн 25-р хорооны 36Б байрны оршин суугч Н.Баасанжавтай холбогдож тус лифт нь Монгол Улсын засгийн газар Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газрын хооронд байгуулсан "Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд "Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх төсөл"-ийн шинэчлэгдэх лифтний жагсаалтад орсон талаар тайлбарлаж мэдэгдэв. Иргэн Н.Баасанжавтай "Улаанбаатар лифт НӨҮГ"-ын ерөнхий инженер М.Энхбат миний бие биечлэн уулзаж нөхцөл байдлыг сонсож төслийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж санал бодлоо солилцсон болно.</p>
---	----------------------	---	---

		хэрэгтэй байна" гэсэн санал хэлсэн болно. 11. 2022.02.09 нд НМХГ-ын мэргэжилтэн Н.Гансүхэд 36Б байрны лифтний үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргуулах өргөдөл өгөв. 12. 2022.03.02-нд МШ-р НМХГ-с баталгаажсан бичиг ирүүлсэн. 13. Манай байрны энэ дүгнэлт 2018 онд гарсан боловч Говь СӨХ-ны удирдлага үүнийг тас нууж оршин суугч биднийг хохироож ирсэн байна. 14. Бид байрандаа иргэний үүргээ биелүүлж олон төрлийн ажил хийдэг, мод зүлэг цэцэг тарих, өнжмөл өвсөө өөрсдөө зулгааж цэвэрлэгээ хийх, корона вирусын үед 2-3 удаа их цэвэрлэгээ ариутгал хийх, давхрын болон давхрын шатыг пелтажуулах, пункерын цонхыг вакумжуулах, байрандаа пасад хийлгэх талаар сүүлийн 4 жил хөөцөлдөж Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээг Захирагчийн ажлын албаны шийдвэрээр 2020.08.17-нд хийлгэсэн гэх зэргээр олон ажил хийсэн боловч манай СӨХ дэмжиж ажилладаггүй. 15. Бид хот дүүргээс дэвшүүлж буй эко гудамж -эко хороо болон амьдрах санал санаачлагыг дэмжиж олон төрлийн ажлууд хийж ирлээ. Та бүхэн БЗД-ийн 25-р хорооны 36Б байрны лифтийг шинэчилж өгнө үү.	
7	Хүсэлт 2022-04-08	Сайн байна уу? Миний бие нь өмнө нь. Чингэлтэй дүүрэгт байрлах Бөмбөгөр худалдааны төвийн баруун талд байрлах гүүрэн гарцны цахилгаан лифтний талаар гомдол бичсэний дагуу дөрвөн улирал дараалан байнгын ажиллагаатай болгох талаар өөр лифтэнд туршилт хийж байгаа. Мөн 4 сард ашиглалтад оруулна гэсэн юм. Хэзээнээс ажиллагаатай болгох талаар хариу өгнө үү.	2022-04-13 Ерөнхий инженер М.Энхбат: Хүсэлтийн дагуу иргэн Т.Баттөмөртэй холбогдож хэрэв төсөв батлагдвал гүүрэн гарцны цахилгаан шатнуудыг 4 сарын 15-наас ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар мэдэгдэж тайлбарлав.
8	Гомдол 2022-04-11	ХУД-ийн 120 мянгатын явган зорчигчдын гүүрэн гарцын лифт нь ажиллахгүй байна. Хүүхдээ тэргэн дээр түрж яваа иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд аюулгүй зам гарах ямар ч боломжгүйгээс эрсдэлд орж, гарцгүй газраар зам хөндлөн гарч байна. Холбогдох газар нь яаралтай арга хэмжээ авч, шийдвэрлэж өгмөөр байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	2022-04-13 Ерөнхий инженер М.Энхбат: Хүсэлтийн дагуу иргэн Э.Болор-Эрдэнэтэй холбогдож төсөв батлагдвал 2022 оны 4 сарын 15-наас 120 мянгатын гүүрэн гарцны цахилгаан шатыг явуулах бэлтгэл ажил хангагдсан талаар мэдэгдэв.
9	Гомдол 2022-04-22	Иргэн миний 4 дүгээр сарын 19 болон 20-ны өдөр гаргасан гомдлын	2022-04-25

		<p>дагуу надтай утсаар холбогдож шийдвэрлэлтийн талаар мэдээлэл өгсөн. Гэтэл тус ажилтны өгсөн шийдвэрлэлтийн мэдээлэл нь "Өвөл ажилладаг лифт болон зун ажилладаг лифт байдаг" гэсэн. Өнөөдөр өглөө Монголын үндэсний радиогоор бүх гүүрэн гарцуудыг өнөөдрөөс эхлээд ажиллуулна гэсэн мэдээлэл гарсан. Тус мэдээлэлд үндэслэн Хан-Уул дүүргийн гүүрэн гарцаар үйлчлүүлэх гэтэл тус гүүрэн гарц мөн ажиллагаагүй байсан. Өвөл тог цахилгаан байж л байдаг шүү дээ. Өвөл ажилладаггүй гүүрэн гарц байгаад яах юм бэ? Өндөр настай иргэд тус гүүрэн гарцаар үйлчлүүлэх хэрэгцээ их байдаг. Тус лифтийг ажиллуулах үүрэгтэй хүмүүс нь өвөл, зун гэлтгүй улсын төсвөөс цалинжиж байгаа шүү дээ. Өвөл ажилладаггүй юм бол тус гүүрэн гарцыг хариуцдаг ажилтнаар яах юм бэ? Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү.</p>	<p>Ерөнхий инженер М.Энхбат: Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэн Б.Баярсайханы гомдлын дагуу гэмтэл гарсан шалтгааныг тодруулж лифтийг хэвийн ажиллагаанд оруулан гомдол гаргагчид эргэж мэдэгдсэн. Тус лифтний 1-р давхарын хонгилийн хаалганы мэдрэгчийн контактар гадны нөлөөтэй хугарч гэмтсэний улмаас хаалга хаагдахгүй зогссон байсныг зассан. Тус лифт нь техникийн нөхцөлийн дагуу +5-аас +40 хэмийн градуст ажиллах горимтой. Бүх гүүрэн гарцны лифт 4-р сарын 15-ны өдрөөс 11-р сарын 15 хүртэл ажилладаг. Тиймээс 4 гүүрэн гарцны 8 лифт 2022 оны 4-р сарын 15-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.</p>
11	Хүсэлт 2022-05-06	<p>Ахмад настай болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Улаанбаатар хотод байгаа явган иргэдийн "Гүүрэн гарц"-р зорчих шаардлагатай байхад цахилгаан шат нь ажиллахгүй байна. Бөмбөгөр болон 100 айл орчимд байдаг "Гүүрэн гарц"-ы лифтээр иргэн миний бие /хөгжлийн бэрхшээлтэй/ зорчиход үнэхээр хүндрэлтэй байна. Тус газруудынхаа лифт буюу цахилгаан шатыг яаралтай ажиллагаанд оруулж өгнө үү. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү.</p>	<p>2022-05-17 Ерөнхий инженер М.Энхбат: Бөмбөгөр болон 100 айлын гүүрэн гарцнуудын цахилгаан шат 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн өдөр бүр ажлын өдрүүдэд 07.30-21.00 цаг хүртэл, амралтын өдрүүдэд 09-19 цаг хүртэл тогтмол ажиллаж байгаа талаар хүсэлт гаргасан иргэн Б.Шүрэнцэцэгт утсаар ярьж мэдэгдсэн.</p>
13	Хүсэлт 2022-10-12	<p>БЗД-ийн 18-р хороо, 14, 22а-р байрнуудын лифт ашиглалтын хугацаа эрт дууссан болохоор шинэчлэх талаар 2023 оны төсөвт суулгаж өгөхийг хүсэж байна.</p>	<p>2022-10-14 Хяналтын инженер Ц.Уранбилэг: Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны 14, 22а дугаар байрнуудын цахилгаан шатууд нь Нийслэлийн хэмжээнд ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 139 цахилгаан шатны жагсаалтад орсон. Дээрх цахилгаан шатуудыг Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар шинэчлүүлэх саналыг жил бүр НЗДТГ болон УБЗАА-нд хүргүүлдэг боловч төсөв батлагддаггүй болно.</p>
14	Гомдол	<p>ХУД-ийн байрны автобусны буудал дээрх гүүрэн гарцын цахилгаан</p>	<p>2022-10-31</p>

	2022-10-28	шат нь ажиллахгүй байна. Энэ цахилгаан шат нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад хамгийн хэрэгтэй зүйл шүү дээ. Хаалга нь онгойдог хэр нь дээшээ явдаггүй. Үүнийг холбогдох байгууллагад нь уламжилж, засварлаж, хариу өгнө үү.	Дарга Д.Ган-Эрдэнэ: Лифтний хаалгыг байгууллагын инженер техникийн ажилчид очиж үзэн хэвийн байдалд оруулсан болно. Мөн иргэнд хариу утсаар мэдэгдсэн.
18	Санал 2022-12-16	БЗД-ийн, 6-р хорооны КЗ дугаар байрны цахилгаан шатыг улсын төсвөөр шинээр сольж өгнө үү.	2022-12-21 Хяналтын инженер Ц.Уранбилэг: Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх төсөл”-өөр ашиглалтын хугацаа нь дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 139 лифтний жагсаалтад Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны КЗ байрны лифт нь орсон боловч тус төслийн зээлийн эргэн төлөлт нь тодорхойгүй, цаг үеийн нөхцөл байдал (дайны нөхцөл)-аас шалтгаалан хэрэгжих нь тодорхойгүй болсон. Иймд 139 цахилгаан шатыг жил бүр үе шаттайгаар шинэчлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн тухай мэдээллийг өгсөн.